



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Үндсэн болон эргэлтийн хөрөнгө
балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, 2015 оны 501 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Тяньжины боомт дахь “Улаанбаатар төлөөлөгчийн газар” улсын төсөвт үйлдвэрийн газар татан буугдсантай холбогдуулан нийт 14,037,066.00 (арван дөрвөн сая гучин долоон мянга жаран зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгө, 2,559,300.00 (хоёр сая таван зуун тавин есөн мянга гурван зуун) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан эргэлтийн хөрөнгийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам тээврийн, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн
.....дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**БНХАУ-ын Тяньжины боомт дахь "Улаанбаатар төлөөлөгчийн газар" улсын төсөвт үйлдвэрийн газрын
балансаас "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн балансад
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**



Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Бичгийн ширээ У55	2009.11.10	ш	9	123,386.11	1,110,475.00	1,110,475.00	0.00
2	Сандаг	2009.11.10	ш	1	296,700.00	296,700.00	296,700.00	0.00
3	Уулзалтын ширээ	2009.11.10	ш	1	279,500.00	279,500.00	279,500.00	0.00
4	Сандаг	2009.11.10	ш	16	68,812.50	1,101,000.00	1,101,000.00	0.00
5	Уулзалтын буйдан	2009.11.10	ком	1	569,750.00	569,750.00	569,750.00	0.00
6	Буйдан /Ком/	2009.11.10	ш	1	829,900.00	829,900.00	829,900.00	0.00
7	Угтвар ширээ	2009.11.10	ком	1	138,891.00	138,891.00	138,891.00	0.00
8	Принтер HP1020	2009.11.10	ш	1	559,000.00	559,000.00	559,000.00	0.00
9	Принтер HP-CP1215	2009.11.10	ш	1	323,000.00	323,000.00	323,000.00	0.00
10	Цаас хэрчигч	2009.11.10	ш	1	126,850.00	126,850.00	126,850.00	0.00
11	Эсгий гэр, тавилгатай	2012.05.15	ком	1	2,150,000.00	2,150,000.00	2,150,000.00	0.00
12	Компьютер Dell	2009.11.10	ш	8	819,000.00	6,552,000.00	6,552,000.00	0.00
НИЙТ ДҮН:				42	6,284,789.61 (зургаан сая хоёр зуун наян дөрвөн мянга долоон зуун наян есөн төгрөг жаран нэгэн мөнгө)	14,037,066.00 (арван дөрвөн сая гучин долоон мянга жаран зургаан)	14,037,066.00 (арван дөрвөн сая гучин долоон мянга жаран зургаан)	0.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн
192 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

БНХАУ-ын Тяньжины боомт дахь "Улаанбаатар төлөөлөгчийн газар"
улсын төсөвт үйлдвэрийн газрын балансаас
"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн балансад
шилжүүлэх эргэлтийн хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт үнэ (төгрөг)
1	Бичиг хэргийн материал	880,750.00
3	Аж ахуйн материал	1,678,550.00
	Нийт бараа, материалын дүн	2,559,300.00 (хоёр сая таван зуун тавин есөн мянга гурван зуун)